



МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 05 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Нэгдсэн удирдамж батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.5 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэгдсэн удирдамж”-ийг нэгдүгээр, “Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний хуваарь”-ийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөөг баталж, удирдлага зохицуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газар (хошууч генерал Г.Ариунбуян)-т үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Шадар сайдын ахлах зөвлөх бөгөөд Ажлын албаны дарга (А.Даваажаргал)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД



Х.ГАНХУЯГ

0026100111

Монгол Улсын Шадар сайдын
2026 оны ... дугаар сарын ... -ны
өдрийн ... дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН УДИРДАМЖ**

Нэг. Үндэслэл

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор баталсан “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги”, Шадар сайдын 2025 оны 188 дугаар тушаалаар батлагдсан “Дунд хугацааны стратегийг хэрэгжүүлэх III үе шат (2026-2030 он)-ны арга хэмжээний төлөвлөгөө” нь Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний нэгдсэн удирдамж (цаашид “нэгдсэн удирдамж” гэх)-ийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болно.

1.2. Монгол Улсад тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын тоо сүүлийн арван жил буюу 2015-2024 онд өмнөх арван жил (2005-2014)-ийн дунджаас 26 хувь, амь насаа алдсан хүний тоо 14 хувь, шууд учирсан хохирлын хэмжээ 1,8 дахин өссөн, цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай байгаа тул гамшгийн эрсдэлийн мэдээлэл, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналт, судалгаа шинжилгээний үр дүнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг өргөжүүлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангах шаардлага тулгарч байна.

Хоёр. Зорилго

2.1. Байгалийн болон хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх түвшний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд зохион байгуулах, гамшгийн эрсдэлийн тухай ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах дадал хэвшлийг төлөвшүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлыг эрчимжүүлэхэд энэхүү нэгдсэн удирдамжийн зорилго оршино.

Гурав. Хамрах хүрээ, хугацаа

3.1. Бүх түвшний засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хэмжээнд зохион байгуулна.

3.2. Гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, айл өрх, иргэд (хүүхэд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, өндөр настан, алслагдмал нутгийн иргэд, хэнийг ч орхигдуулахгүй байх)-ийг хамрах байдлаар зохион байгуулна.

3.3. Нэгдсэн удирдамжийг 2026-2030 он хүртэл хугацаанд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээний удирдлага, зохион байгуулалт

4.1.Монгол Улсад зонхилон тохиолдох гамшиг, аюулт үзэгдэл, ослын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүс нутаг, улирал, болзошгүй эрсдэлийн шинж чанар, онцлогт нийцүүлэн зохион байгуулна.

4.2.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээг улс, орон нутаг, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн түвшинд зохион байгуулна.

4.2.1.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэхэд улсын хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газар, орон нутгийн түвшинд төв, орон нутгийн Онцгой байдлын газар, анги, хэлтэс удирдлага, зохион байгуулалтаар хангана. Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний болон орон нутгийн зөвлөл, бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, Гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, мөн улсын болон тухайн шатны онцгой комисс болон бусад холбогдох талууд чиг үүргийн дагуу дэмжлэг үзүүлэн ажиллана.

4.2.2.Аж ахуйн нэгж байгууллага, хуулийн этгээдийн дарга, удирдлага байгууллагын гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг, ажилтан, ажилчдад гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, чадвар олгох арга хэмжээг зохион байгуулна.

4.2.3.Айл өрх, иргэн бүр өөрийн аюулгүй байдлыг хангаж, гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд оролцож, гамшгаас хамгаалах ойлголт, мэдлэг, чадвараа бататгана.

4.3.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөөг улсын хэмжээнд Онцгой байдлын ерөнхий газрын дарга жил бүрийн 12 дугаар сард батална. Жилийн төлөвлөгөөнд нэгдсэн удирдамжид заасан арга хэмжээг нарийвчлан, тухайн жилд онцлох арга хэмжээг нэмэлтээр тусгана. Тухайн жилийн төлөвлөгөөг орон нутагт удирдлага болгон хэрэгжүүлнэ.

4.4.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээнд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, судалгаа шинжилгээний болон олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэдийн сайн дурын оролцоо, хамтын ажиллагааг эрхэмлэнэ.

Тав. Хэрэгжүүлэх арга хэмжээ

5.1.Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд гамшгийн эрсдэлийг ойлгох, үнэлэх, болзошгүй хохирлын хэмжээг багасгах, урьдчилан сэргийлэх бүх төрлийн сургалт, сурталчилгаа, бэлэн байдлыг хангах төлөвлөлт, хяналт шалгалтын арга хэмжээ болон түүний мөрөөр авсан арга хэмжээ, иргэд, олон нийтэд гамшгийн болон эрсдэлийн мэдээлэл, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг цаг тухайд зарлан мэдээлэх, хүртээмжтэй хүргэх арга хэмжээг тусгаж дараах гамшгийн төрлөөр авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- 5.1.1. Ой, хээрийн гал түймэр
- 5.1.2. Объектын гал түймэр
- 5.1.3. Усны осол
- 5.1.4. Үер (шар усны үер, гол мөрний, гэнэтийн үер)
- 5.1.5. Хүчтэй салхи шуурга (цасан болон шороон шуурга)
- 5.1.6. Ган, зуд
- 5.1.7. Газар хөдлөлт
- 5.1.8. Бусад /бусад гамшгийн төрөл, нэмэлт арга хэмжээг төлөвлөнө/

5.2.Гамшгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн удирдамжийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээг холбогдох талууд хэвлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр тухай бүр нийтэд мэдээлнэ.

Зургаа. Төсөв санхүү

6.1.Улс, орон нутгийн төсөв, дотоодын болон гадаад улс, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалт, бусад эх үүсвэрээр санхүүжүүлнэ.

Долоо. Тайлан гаргах, хянах

7.1.Нэгдсэн удирдамжийг хэрэгжүүлэх арга хэмжээний жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтэд Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газар, Гамшгаас хамгаалах сургалтын газар, Ажиллагааны удирдлагын газар, Гал түймэртэй тэмцэх газар хяналт чиг үүргийн дагуу тавьж ажиллана. Бусад газар, нэгж дэмжлэг үзүүлнэ.

7.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын газар, анги, хэлтэс удирдамжид заасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 06 дугаар сарын 20, 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тайлан гаргах загварын дагуу зураг, нотломжийн хамт гаргаж, Онцгой байдлын ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын газарт хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд бичмэл тайлан гаргана.

7.3.Улсын хэмжээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан мэдээг Шадар сайдын ажлын албанд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

---oOo---

Товчилсон үгийн тайлбар:

БОУАӨЯ	Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яам
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГЗБГЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези зураг ерөнхий газар
ГХУА	Гамшгаас хамгаалах улсын алба
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОГ	Ойн газар
ЦУОШГ	Цаг уур орчны шинжилгээний газар
МУЗН	Монголын Улаан Загалмай нийгэмлэг
МЗЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
ГСҮХ	Гамшиг судлалын үндэсний хүрээлэн Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэн
ШУАГХ	Үндэсний статистикийн хороо
ҮСХ	Улсын онцгой комиссын ажлын алба
УОКАА	Засаг даргын Тамгын газар
ЗДТГ	Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага
ТОНОББ	